

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дарив сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2024/133/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2024 он	Дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 70483413 Цахим хаяг: Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn “Цэгц төв богд аудит” ХХК-ийн Ахлах аудитор Р.Цанжидмаа Утас: 99029885 Цахим хаяг: tsania.0215@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

40240316 № 29

танай _____ -ны № _____ -т

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дарив сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн Дарив сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар жилийн эцэст эм, боох материалын үлдэгдлийг тоолоогүй, тооцоо бодоогүй, шатахууныг анхан шатны баримтыг үндэслэн орлого аваагүй, шууд зардал болгосон, эмийн тендерт шалгараагүй этгээдээс эмийн худалдан авалт хийсэн, эдийн засгийн ангилал зөрчин гүйлгэн зарцуулсан, ээлжийн амралтын цалинг тоцоолсон цалинд оруулаагүй, ажилтнуудын цалинг нийгмийн даатгал, татварын тайланд дутуу тайлагнасан, хувь хүний орлогын албан татварын дутуу төлөлтийг тайлагнаагүй, тооцоо нийлж, баталгаажуулаагүй, хугацаа дууссан эм, боох материалыг акталж устгах талаар арга хэмжээ аваагүй, үр дүнгийн урамшуулал давхардуулан олгосон, илүү цагийн хөлс үндэслэлгүй олгосон, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй зэрэг 133,485.4 мянган төгрөгийн материаллаг зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалт, УСНББОУС 1-ийн 27, 28 дахь заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, үнэн зөв, бодитой, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус Эрүүл мэндийн төв тайлант онд Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гэрээний дагуу 1756 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

07020069

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээний болон нэг иргэнд ногдох санхүүжилт 514,782.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс байр ашиглалттай холбоотой зардлын санхүүжилт 35,048.0 мянган төгрөг, хандив тусламжаар 121,757.4 мянган төгрөгийн эм бэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл үнэ төлбөргүй хүлээн авч орлогдсон байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэл хөтөлдөггүй, эмийн болон хүнс, бусад бараа материалын нэр төрлийн тайланг сар бүр гаргадаггүй, нягтлан бодогч хөрөнгийн үлдэгдлийг нягтлан бодох бүртгэлийн үлдэгдэлтэй тулгаж тооцоо боддоггүй, үндсэн хөрөнгийг жилд нэг удаа, эргэлтийн хөрөнгийг хагас бүтэн жилээр тоолох ажлыг зохион байгуулдаггүй зэргээс шалтгаалан ихээхэн хэмжээний материаллаг зөрчил гарсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 4 хөтөлбөр, 45 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 28 арга хэмжээг 100.0 хувь, 7 арга хэмжээг 90.0-95.0 хувь, 5 арга хэмжээг 80.0-90.0 хувь, 3 арга хэмжээг 40.0-50.0 хувь, 2 арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна. Сумын Засаг дарга 91.0 хувиар биелэлтийг үнэлсэн. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ худалдан авах гэрээгээр 81.5 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Г.ГҮНЖИДМАА



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

		/сая.төгрөг/	
Үзүүлэлт		2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
Эргэлтийн хөрөнгийн дүн		170,145.6	121,982.3
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		1,434,150.6	1,431,746.9
Нийт хөрөнгийн дүн		1,604,296.2	1,553,729.2
Нийт өр төлбөрийн дүн		4,145.2	1,047.4
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн		1,600,151.0	1,552,681.8
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн		1,604,296.2	1,553,729.2
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
Үйл ажиллагааны орлогын дүн		2,126,648.8	677,391.3
Үйл ажиллагааны зардлын дүн		563,280.3	724,860.4
Үйл ажиллагааны үр дүн		1,563,368.5	(47,469.1)
Үйл ажиллагааны бус үр дүн		-	-
Үйл ажиллагааны нийт үр дүн		1,563,368.5	(47,469.1)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		36,782.4	1,600,150.9
Тайлант оны үр дүн		1,563,368.5	(47,469.1)
Эцсийн үлдэгдэл		1,600,150.9	1,553,729.2
Мөнгөн гүйлгээний тайлан			
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн		520,094.5	549,830.5
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн		459,086.5	564,448.3
Үйл ажиллагааны ЦМГ		61,008.0	(14,617.8)
Хөрөнгө оруулалтын ЦМГ		(6,139.0)	(24,490.0)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ		-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		54,869.00	(39,107.8)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	54,868.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		54,869.00	15,761.2
Төсвийн гүйцэтгэлийн тайлан УТ			
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн			553,890.3
Урсгал зардал			553,890.3
Хөрөнгийн зардал			-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр			514,782.5
Эрүүл мэндийн даатгалын сангаас			514,782.5
Туслах үйл ажиллагааны орлогоос			-
Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл			15,761.2
Төсвийн гүйцэтгэлийн тайлан ОН			
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн			32,444.1
Урсгал зардал			32,444.1
Хөрөнгийн зардал			-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр			32,444.1
Орон нутгийн төсвөөс санхүүжих			32,444.1

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар илэрсэн нийт 131.5 сая төгрөгийн 14 зөрчлөөс 1.4 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт, 130.1 сая төгрөгийн 12 зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага, хариуцлага тооцох албан шаардлага өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Эрүүл мэндийн төвийн даргад даргад үр дүнгийн урамшуулал 3,4 дүгээр сард 0.8 сая төгрөг давхардуулан олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2 дугаар зүйлийн 2.3-т "Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана", 3 дугаар зүйлийн 3.12-т "Эрүүл мэндийн байгууллагын даргын ажлын үр дүнг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон тухайн албан тушаалтныг томилсон эрх бүхий албан тушаалтан дүгнэж, шийдвэр гаргана" гэж заасныг зөрчиж байна.

Шийдвэрлсэн нь: Төсвийг хохиролгүй болгох төлбөрийн акт тогтоосон.

2. Нягтлан бодогчоор ажиллаж байсан ажилтан 2-8 дугаар сард 0.5 сая төгрөгийн илүү цагийн хөлс бодож авсан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.3-т "Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу төрийн байгууллагын дотоод журмаар тогтоосон өдрийн ажлын цагийг ажил олгогчийн санаачлагаар хэтрүүлэн ажиллуулахыг илүү цагаар ажиллуулсанд, орон нутгийн цагаар 22 цагаас 06 цаг хүртэлх хугацаанд ажиллуулахыг шөнийн цагаар ажиллуулсанд, нийтээр амрах баярын өдрүүдэд ажиллуулахыг нийтээр амрах баярын өдөр ажиллуулсанд, Бямба, Ням гарагт ажиллуулахыг долоо хоног бүрийн амралтын өдөр ажиллуулсанд тус тус тооцож, нөхөн амруулаагүй тохиолдолд нэмэгдэл хөлс олгоно". 3 дугаар зүйлийн 3.1-т "Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ"-ыг зөрчсөн байна.

Шийдвэрлсэн нь: Төсвийг хохиролгүй болгох төлбөрийн акт тогтоосон

5.2 Албан шаардлага

1. Улирлын үр дүнгийн урамшуулал 6.4 сая төгрөгийг 3,4 дүгээр саруудад давхардуулан олгосон байна. Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2 дугаар зүйлийн 2.3-т "Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана"-ын зөрчсөн.



Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийн давтан гаргахгүй байх албан шаардлага

2. Эм боох материалын үлдэгдэлд хугацаа дууссан 27 нэр төрлийн 1134 ширхэг 0.4 сая төгрөгийн эм бэлдмэл байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-т "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх"-тэй нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Дотоодын хяналтыг сайжруулан хугацаа дууссан эмийг холбогдох журмын дагуу шийдвэрлэж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

3. Тендерт шалгараагүй этгээдээс 9.7 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тендерт шалгарсан этгээдээс худалдан авалт хийж байх албан шаардлага хүргүүлсэн.

4. Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл 8.2 сая төгрөгийг цалингийн зардлын төсвөөс зарцуулж, цалингийн зардлаар тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж, нягтлан бодох бүртгэл хөтлөх албан шаардлага өгсөн.

5. Нийт 9 ажилтны ээлжийн амралтын цалин 5.6 сая төгрөгийг тооцоолсон цалинд оруулаагүй нь Төсвийн тухай хуулийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", -ыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатын баримтанд үндэслэн Нягтлан бодох бүртгэл хөтөлж, тайлан гаргах албан шаардлага өгсөн.

6.Дээрх 9 ажилтны цалингийн орлого 5.4 сая төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд дутуу тайлагнасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1.1-т /хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;/Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйл, 16.1 дэх заалт /Ажил олгогч нь даатгуулагчийн төлбөр зохих нийгмийн даатгалын шимтгэлийг түүнд хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого олох бүртээ энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр тооцон суутгаж, тухайн сард нь багтаан нийгмийндаатгалын санд шилжүүлнэ./-ыг зөрчсөн.

Шийдвэрлсэн нь: Ажилтнуудын цалингийн орлогыг нийгмийн даатгалын тайланд нөхөн тайлагнах албан шаардлага өгсөн.

7. Ажилтнуудын цалингийн орлого 5.5 сая төгрөгийг татварын тайланд дутуу тайлагнасан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйл, 6.2.Энэ хуулийн 5.5-д заасан Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгчийн тухайн татварын жилд Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлогод албан татвар ногдоно. 7 дугаар зүйл 7.1 7.1.Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна:7.1.1.ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;-той нийцэхгүй байна.

Шийдвэрлсэн нь: Ажилтнуудын цалингийн орлогыг ХХОАТ-ын тайланд нөхөн тайлагнах албан шаардлага өгсөн.

8. Эм бэлдмэлийн үнэ 1.5 төгрөгийг орлого аваагүй шууд зарлагаар тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;"-ыг зөрчсөн.

Шийдвэрлсэн нь: Нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтөлж байх албан шаардлага хүргүүлсэн.

9. Жилийн эцсийн тооллогоор 59.4 сая төгрөгийн эм боох материалыг тоолоогүй, тооцоо бодоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;/, 20.2.6-т /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр

дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх"ыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн дагуу хөрөнгийн тооллого хийж, баталгаажуулах албан шаардлага өгсөн.

10. Цалингаас суутгасан 2.8 сая төгрөгийн ХХОАТ төлөөгүй тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;" Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-т "ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;"-ыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь. Өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах албан шаардлага өгсөн.

11. Тайлант онд зарцуулсан 25.4 сая төгрөгийн шатахууныг орлого аваагүй шууд зарлага болгосон Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;"

Шийдвэрлэсэн нь. Анхан шатын баримтыг үндэслэн шатахууныг орлого авч нягтлан бодох бүртгэл үнэн зөв хөтлөх албан шаардлага өгсөн.

12. Төрийн аудитын байгууллагаас тогтоосон 2023 оны 01/100, 02/100, 03/100 дугаартай төлбөрийн акт, 04/91, 03/127-07/117 дугаартай албан шаардлагуудыг хэрэгжүүлээгүйбайгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж заасныг зөрчсөн байна.

Мөн аудитаар 131.5 сая төгрөгийн материаллаг зөрчил илэрч Сөрөг дүгнэлт өгсөн нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1. Энэ хуулийн 16 дугаар

зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэж заасан тул сумын Засаг даргад хоблогдох албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага өгсөн.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитын шийдвэр хэрэгжүүлээгүй, Сөрөг дүгнэлт авсан төсвийн захирагчид хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дарив сумын Эрүүл мэндийн төв	15	131.5	2	1.3	12	130.1	-	-	1	-	-	-
Дүн	15	131.5	2	1.3	12	130.1	-	-	1	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	-	-	1	-
	НИЙТ	1	1	-	-	-	-	1	-